



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 1274

Улаанбаатар хот

Барилга акталж, нийслэлийн
өмчийн бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 481 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 113 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Баянзүрх дүүргийн 297 дугаар цэцэрлэгийн барилга баригдсантай холбогдуулан “Өнөр бүл Хүүхдийн төв”-ийн балансад бүртгэлтэй, 5,145,043.00 (таван сая нэг зуун дөчин таван мянга дөчин гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад дурдсан Ногоон зоорийн байрыг акталж, данс бүртгэлээс хасахыг “Өнөр бүл хүүхдийн төв” (М.Өлзийчимэг)-д зөвшөөрсүгэй.

2. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205624

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
...~~21~~... сарын ...~~09~~... өдрийн
...~~Р/12.24~~... захирамжийн
хавсралт



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2024.08.31/	Үлдэгдэл өртөг	Акталж данснаас хасах үндэслэл
1	Өнөр бүл хүүхдийн төвийн Ногоон зоорийн байр	1995	м2	45	5,145,043.00	5,145,043.00		Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Баянзүрх дүүргийн 297 дугаар цэцэрлэгийн шинэ барилга баригдсан
Нийт дүн					5,145,043.00	5,145,043.00		